

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ᠠᠷᠬᠠᠩᠭ᠋ᠠᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤ ᠭᠠᠰᠠᠷ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН
ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨ БАГАТАЙ, ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН 67.8 ХУВИЙГ
ХАНГАСАН БАЙНА.

АУДИТЫН НЭР: УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД:
АРА-2022/16-1-ШТА-ГА



ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2022 ОН

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860 Цахим хаяг: nerguibaatard@audit.gov.mn
Багийн ахлагч, ахлах аудитор Х.Алтанчимэг
Утас: 9006-0105 Цахим хаяг: altanchimegkh@audit.gov.mn
Аудитор Г.Цог-Эрдэнэ
Утас: 9921-0906 Цахим хаяг: Tsog-erdeneg@audit.gov.mn
Аудитор Ж.Мөнгөншагай
Утас: 9090-9190 Цахим хаяг: Mungunshagaij@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Аудитын тайланг
бэлтгэсэн:

Архангай аймаг дахь
Төрийн Аудитын газар

Дарга, Тэргүүлэх
аудитор Т.Байгалмаа

Утас: 70332141

Аудитын менежер

Д.Нэргүйбаатар

Утас: 70332860

Ахлах аудитор

Х.Алтанчимэг

Утас: 70333019

Аудитор

Г.Цог-эрдэнэ

Ж.Мөнгөншагай

**Уг тайланг УАГ-ын
Веб сайт-аас үзнэ үү.**

2022 оны 4 дүгээр сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
дээрх утас, 70332141
дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг: Архангай аймаг,
Эрдэнэбулган сум, 3-р
баг, аймгийн ЗДТГ-ын
байр, А корпус, 3-р
давхар 311 тоот өрөө

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

**Бүлэг 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨ БАГАТАЙ
БАЙНА.**

1.1. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний 12.5 хувийг
нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөөгүй байна.

1.2. Барилга байгууламжийн зураг, төсөл боловсруулах,
түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнтэй байна.

1.3. Төсөл арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын
хэрэгжилтийг хангаагүй байна.

**Бүлэг 2. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР
ХЭРЭГЖСЭН ТАХ-НИЙ 23.2 ХУВИЙГ ҮР ДҮНТЭЙ
ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.**

2.1. Нийт төсөл, арга хэмжээний 93.7 нь худалдан авах
ажиллагааны тендерийн баримт бичигт тавигдсан
шаардлагыг хангасан байна.

2.2. Захиалагч 8-н ТАХ-ний гэрээний хэрэгжилтийг
хугацаанд нь бүрэн хангуулаагүй байна.

2.3. Нийт ТАХ-ний 7.4 хувьд захиалагчийн тавих хяналтыг
үр дүнгүй хэрэгжүүлсэн, аймгийн Засаг даргаас хөрөнгө
оруулалтын үйл явц, хэрэгжилт, үр дүнд дотоод хяналт
шалгалтыг хийгээгүй байна.

2.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 8-н
ТАХ-ний 9,470.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд
тусгаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн 22 хувийг
хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагын санал

Тайлан баталгаажуулсан тушаал

График 1 Хөрөнгө оруулалтын ТАХ-ний төрөл

График 2. УТХО-ын 2017-2021 оны ТАХ-ны ангилал

График 3. Зураг төсөв боловсруулалт

График 4. ЭБ сумын 2-р цэцэрлэгийн суралцагсад

График 5. Хөрөнгө оруулалтын ангилал

График 6. ОНӨГ-ын сүүлийн 5 жилийн ХАА-ны журмын сонголт

График 7. Ашиглалтанд орсон ТАХ-ний мэдээлэл

Хүснэгт 1. Нийт эрх шилжүүлсэн ТАХ-ны төрөл

Хүснэгт 2. Бодлогын баримт бичигт тусгагдаагүй ТАХ

Хүснэгт 3. Санхүүжилтийг оновчгүй тооцож батлуулсан ТАХ-ний жагсаалт

Хүснэгт 4: Гэрээний үүргээ хугацаанд хэрэгжүүлээгүй гүйцэтгэгчийн талаарх
мэдээлэл

Хүснэгт 5. Дуусаагүй орхигдсон барилгын жагсаалт

Хүснэгт 6. Санхүүжилтийн зарцуулалт

Хүснэгт 7. ТАХ-ний санхүүжилт ТЕЗ нараар

Хүснэгт 8: Барьцаа хөрөнгийн дансны гүйлгээний нэгтгэл

Барьцаа хөрөнгийн дансан дахь үлдэгдэл

Хүснэгт 9 : Ашиглалтанд хүлээн авсан ТАХ

Хүснэгт 10: Бүртгэлд тусгаагүй хөрөнгийн жагсаалт

Хүснэгт 11: Өмнөх зөвлөмжийн тоо



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГУУДЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ
БОАЖС	БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД
БШУСС	БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД
БХБС	БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД
ГА	ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ
ГАГ	ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР
ГХБХБГ	ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
ЕБС	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ
ЗГХЭГ	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ЗТХС	ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД
ЗҮБҮА	ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГА ҮНИЙН АРГА
ИТХТ	ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД
НТШ	НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ
ОНӨГ	ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР
ОНХС	ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН
СТСХ	САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС
СХАА	САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБА
ТАХ	ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ
ТББ	ТЕНДЕРИЙГ БАРИМТ БИЧИГ
ТБОНӨХБАҮХАТХ	ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬ
ТЕЗ	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ҮАГ	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ХАА	ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА
ХОХБТХ	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС
ЭМГ	ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
ЭМС	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
ЭМТ	ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ



АУДИТЫН НЭР: Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

АУДИТЫН КОД: АРА-2022/16-1-ШТА-ГА

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын төлөвлөгөөний дагуу хийв.

АУДИТЫН ЗОРИЛТ:

ТЕЗ нараас Орон нутагт эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудит хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, тайланг ҮАГ-т хүргүүлэх болон орон нутгийн удирдлагад бодит мэдээлэл өгөх, шийдвэр гаргах түвшинд туслалцаа үзүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байгаа эсэх

АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

Аудитыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020-2021 онд аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 39, эрх шилжээгүй 22, нийт 61 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан байна. Үүнээс аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн тайланд онд шинээр хэрэгжих 16 ТАХ-ний төлөвлөлт хийсэн судалгаа, шинжилгээний тайлан, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн хийлээ. Аудитад дээрх 61 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллага болон төсөл арга хэмжээний гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамрууллаа.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн

аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

АУДИТАД АШИГЛАХ ШАЛГУУР:

- Тухайн аудитын зорилтыг хангахад чиглэсэн аудитын асуудлын шинжилгээнд тусгагдсан асуултууд (Хавсралт 2);
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжүүд;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт;
- Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”;
- Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”;
- Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд

АУДИТ ХИЙСЭН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Аудитыг аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар үе шатны болон чанарын хяналтыг



хэрэгжүүлэн ажилласан бөгөөд аудитор Г.Цог-эрдэнэ, Ж.Мөнгөншагай нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАХ МЭДЭЭЛЭЛ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ЖУРАМ:

Аудитын тайлан нь аудитын зорилт, дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал болон хавсралт хэсгээс бүрдэнэ.

Аудитын тайлангийн төслийг шалгагдагч этгээдэд танилцуулахаас гадна хамаарал бүхий хэсэгтэй бусад шалгагдагч байгууллагад танилцах боломжийг олгоно. Шалгагдагч этгээдээс санал авч, аудитын тайлангийн эцсийн хувилбарыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ.

Гүйцэтгэлийн аудитын тайлан аудитын асуудлын шинжилгээний 4 дэх түвшний асуулт бүрд хариулт өгч тэмдэглэгээ хийсэн ба 3 дахь түвшний асуултын хүрээнд ерөнхийдөө ангилагдан бичигдсэн болно.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 15 дугаар тогтоолын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч нараас Архангай аймгийн Засаг даргад Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан 37 тэрбум 993.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тухайн онд санхүүжих 23 тэрбум 293.9 сая төгрөгийн дүн бүхий 30 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлсэн ба тайлант жилийн дундуур БШУСайдаас 980.0 сая төгрөгөөр санхүүжих 7, ЭМС-аас 104.5 сая төгрөгөөр санхүүжүүлэх 2 нийт 9 ТАХ-ний эрхийг нэмж шилжүүлсэн байна.

Ингэснээр нийт 39 тэрбум 78.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2021 онд 25 тэрбум 358.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 39 ТАХ болсон байна. Нийт эрх шилжүүлсэн ТАХ ба санхүүжих дүнг ТЕЗ нараар ангилж авч үзвэл:

- БСШУСайдаас эрх шилжүүлсэн 24 төсөл арга хэмжээ, 12 тэрбум 521.4 сая төгрөг
- ЗТХСайдаас эрх шилжүүлсэн 1 арга хэмжээ, 3 тэрбум төгрөг
- ЗГХЭГ-ын даргаас эрх шилжүүлсэн 3 арга хэмжээ, 400.0 сая төгрөг
- БОАЖСайдаас эрх шилжүүлсэн 1 арга хэмжээ, 2 тэрбум төгрөг
- Эрүүл мэндийн сайдаас эрх шилжүүлсэн 2 арга хэмжээ, 104.5 сая төгрөг
- БХБСайдаас эрх шилжүүлсэн 2 арга хэмжээ, 4 тэрбум 82.5 сая төгрөг
- Соёлын Сайдаас эрх шилжүүлсэн 6 арга хэмжээ, 3 тэрбум 250.0 сая төгрөг

Эрх шилжүүлсэн ТАХ-ний 49.4 хувь нь БШУСайдын, 16.1 хувь нь БХБСайдын, 12.8 хувь нь Соёлын Сайдын, 11.8 хувь нь ЗТХСайдын, 7.9 хувь нь БОАЖСайдын, 1.6 хувь нь ЗГХЭГ-ын даргын, 0.4 хувь нь Эрүүл мэндийн сайдын багцаас тус тус санхүүжихээр байв.

Санхүүжилтийн гүйцэтгэлийг авч үзвэл гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу:

1. БСШУСайдын багцаас 12 тэрбум 511.4 сая төгрөг


2. ЗГХЭГ-ын даргын багцаас 375.9 сая төгрөг
3. Соёлын Сайдын багцаас 3 тэрбум 149.3 сая төгрөг
4. БХБСайдын багцаас 4 тэрбум 79.6 сая төгрөг
5. ЭМСайдын багцаас 99.9 сая төгрөг
6. ЗТХСайдын багцаас 134.2

нийт 20 тэрбум 350.3 сая төгрөгийн санхүүжилт аймгийн Төрийн сангийн дансаар дамжиж гүйлгээ хийгдсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 397 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/912 дугаар захирамжийн дагуу 2021 онд улсын төсвийн хөрөнгөөр эрх шилжиж хэрэгжсэн барилга угсралт, их засварын ажлын үлдэгдэл 4,158.7 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.

График 1.

Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын 39 төсөл, арга хэмжээг төрлөөр ангилж харуулбал барилга байгууламж 18 буюу 46.1 хувь, их засвар 16 буюу 41.0 хувь, тоног төхөөрөмж 4 буюу 10.3 хувь, гүүр барих 1 буюу 12.6 хувь тус тус байна.



Дээрхээс гадна Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар батлагдсан Архангай аймагт хэрэгжих аймгийн Засаг даргад эрх шилжүүлээгүй барилга байгууламжийн 11, гүүрийн 1, тоног төхөөрөмжийн 2, өмнөх оноос он дамжсан барилга байгууламжийн 8 нийт 22 төсөл, арга хэмжээ тус тус хэрэгжсэн байна.

Архангай аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 39 ТАХ, эрх шилжүүлээгүй 22 нийт 61 төсөл арга хэмжээнээс тайлант онд 6 нь санхүүжилт олгогдоогүй тул хэрэгжээгүй, 15 нь дараа онд шилжин хэрэгжих буюу гэрээний хугацаа дуусах болоогүй байна. Харин 40 ТАХ нь тайлант онд ашиглалтанд орох гэрээтэйгээс 26 -н ТАХ бүрэн хэрэгжсэн, 14 нь дараа онд дамжсан байна.

Архангай аймгийн Засагд даргад ТЕЗ нараас эрх шилжүүлсэн 39 төсөл арга хэмжээнээс 31 ТАХ нь тайлант онд бүрэн хэрэгжихээс 21 хэрэгжсэн буюу төлөвлөгөөний хэрэгжилт 67.8 хувьтай байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨ БАГАТАЙ БАЙНА.

А.1. Эрх шилжүүлсэн нийт төсөл арга хэмжээний 87.5 хувь нь нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөгдсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас аймгийн Засаг даргад 2021 онд 39 тэрбум 78.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тайлант онд 25 тэрбум 358.4 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 39 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна. Үүнээс өмнөх оноос шилжсэн 23 ТАХ байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс үзнэ үү/


Нийт эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээг төрлөөр авч үзвэл:

Хүснэгт 1.

	2021 онд	Өмнөх оноос	Нийт
Барилга байгууламж	1	17	18
Их засвар	12	4	16
Авто зам, гүүр		1	1
Тоног төхөөрөмж	3	1	4
	16	23	39

Архангай аймагт сүүлийн 5 жил буюу 2017-2021 онд улсын төсвөөс хэрэгжүүлсэн ТАХ-г төрлөөр нь ангилж харуулбал дараах байдалтай байна.

График 2.



Улсын төсвийн эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын тухайд барилга байгууламж барих ажил 2017-2018 онд 4 байсан бол 2019 онд 24, 2020 онд 31 болж өссөн бол 2021 онд 18 болж буурсан, их засварын ажил 2017 онд 13 байсан бол 2021 онд 16 болж өссөн харин тоног төхөөрөмж худалдан авах нь жил бүр 1-4 буюу тогтмол байснаа 2020 онд 22 болж эрс өссөн бол 2021 онд 4 болж буурчээ. Мөн 2018 оноос



зураг төсөв боловсруулах ажил 4 байсан бол 2021 онд байхгүй, авто зам, гүүр барих ажил 2019 онд 5 байсан бол 2021 онд 1 болж буурчээ.

А.1.1. Жагсаалтанд батлагдсан шинээр хэрэгжих төсөл арга хэмжээний 12.5 хувь нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, МУЗГ-ын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг баримт бичигт тусгагдаагүй байна.

МУЗГ-ын тогтоолоор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын 39 /нийт 61-өөс/ төсөл арга хэмжээнээс шинээр хэрэгжүүлэх 16 ТАХ-г Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг урт болон дунд хугацааны хөтөлбөрийн бодлогын баримт бичгүүдтэй тулган шалгахад 87.5% нь бодлогын баримт бичигт тусгагдсан харин дараах 2 ТАХ нь аль нэг баримт бичигт тусгагдаагүй байна. /зарим ойролцоо утгатай ТАХ-г тусгасанаар авсан/

Хүснэгт 2.

№	ТАХ-ний нэр	төсөвт өртөг/сая.төг/
1	Архангай аймгийн Ихтамир сумын ЗДТГ-ын их засвар	300.0
2	Сум, багийн хөгжлийг дэмжих төсөл	100.0
Дүн		400.0

А.1.2. ТЕЗ нараас 2021 онд шинээр хэрэгжүүлэх эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний 56.3 хувь нь аймгийн Засаг даргаас Ерөнхий сайд болон ТЕЗ нарт гаргаж хүргүүлсэн хөрөнгө оруулалтын саналд тусгагдаагүй байна.

Эрх шилжүүлсэн ТАХ-ний жагсаалтыг аймгийн Засаг даргаас БСУШЯ, ЭМЯ, ХЗДХЯ, ЗТЯ, БОАЖЯ, БХБЯ-ны ТЕЗ нарт 2020.04.30-ны өдрийн 02/554 тоот албан бичгээр хүргүүлсэн “2021 онд улсын төсвөөр хэрэгжүүлэх ТАХ-ний саналын жагсаалт”-тай тулган шалгалаа. Ингэхэд 2021 онд шинээр хэрэгжих 16 ТАХ-ний 7 буюу 43.7 хувь нь энэхүү жагсаалтанд тусгагдсан, 56.3 хувь нь тусгагдаагүй байна. Харин ашиглагч байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт албан бичгийн хуулбарыг тулган шалгахад жагсаалтад тусгагдсан 7 төсөл, арга хэмжээнд саналыг авч нэгтгэсэн байна.

А.1.3. Дээрх нөхцөл байдлаас харахад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ТАХ-ний саналыг сум, байгууллагаас авч аймгийн хэмжээнд нэгтгэн, холбогдох ТЕЗ-д албан ёсоор хүргүүлж байгаа ч Сангийн яам холбогдох ТЕЗ-даас саналд тусгагдаагүй хөрөнгө оруулалтын арга хэмжээг жагсаалтад оруулан төлөвлөж батлуулснаас УТХО-ын төлөвлөлтийн тогтолцоо алдагдсан байна.

А.2. Барилга, байгууламжийн зураг, төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнтэй байна.

А.2.1. Шинээр хэрэгжүүлэх ТАХ-нд техникийн нөхцөл, газрын зөвшөөрөл зэргийг үндэслэж зураг төсвийг боловсруулсан байна.

Архангай аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 2021 онд шинээр хэрэгжүүлэх нийт ТАХ-нээс барилга байгууламжийн 1, их засварын 12 ТАХ нь ажлын даалгавар зураг төсөв боловсруулахаар байна. Үүнээс Эрдэнэбулган сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажилд геологийн дүгнэлт, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлд үндэслэж зураг төсвийг боловсруулсан байна. Мөн шинээр хэрэгжүүлсэн их засварын 12 ТАХ-нд ажлын даалгавар боловсруулжээ.

А.2.2. Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн зураг төслийг мэргэжлийн байгууллага боловсруулж, баталгаажуулсан байна.

2021 онд шинээр хэрэгжүүлсэн барилга байгууламж, их засварын 13 ТАХ-нээс 5 ТАХ нь ажлын даалгавартай үлдэгдэл 8 ТАХ-ний зураг төсвийг боловсруулахаар мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулсан байна. Зураг төсөв боловсруулсан ТАХ-г мэргэжлийн байгууллагаар ангилан харуулбал:

График 3.



Графикаас харахад эрх шилжүүлсэн барилга байгууламж, их засварын ажлын 8 ТАХ-ний зураг төсвийг зураг төсөв боловсруулах мэргэжлийн 4-н ААН-ээр гүйцэтгүүлсэн байна.

А.2.3. Зураг төсөв зохиох зардлыг бодит гүйцэтгэлд үндэслэж шилжүүлсэн байна.

Нийт 8-н ТАХ-ний зураг төсвийг 156.0 сая төгрөгөөр боловсруулах гэрээ байгуулснаас 2021 онд 7 ТАХ-ний бодит гүйцэтгэлд үндэслэж 119.2 сая төгрөгийг олгосон байна. Үлдэх 1 ТАХ-нь гэрээний хугацаагаар дараа онд шилжсэн тул барьцаа хөрөнгийн дансанд үлдээсэн байна.

А.2.4. Барилга байгууламжийн 1 төсөл, арга хэмжээний зураг төсвийг магадлалаар баталгаажуулсан байна.

Шинээр хэрэгжүүлэх Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажлын зураг төсвийг БХБЯ-ны Барилгын хөгжлийн төвөөс 2021.05.29-ны 503/2021 дугаар магадлалын дүгнэлтээр барилгын ажлын төсвийг 1 тэрбум 695.5 сая төгрөгөөр хянаж баталгаажуулжээ. Гүйцэтгэгч "РСТ"ХХК нь 1 тэрбум 560.2 сая төгрөгөөр 2021.08.01-2022.08.25-ны хооронд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан байна.

А.2.5. Барилга байгууламжийн төсөл арга хэмжээний магадлалын дүгнэлтийг мэргэжлийн экспертүүд хянаж баталгаажуулсан байна.

Шинээр хэрэгжүүлэх Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажлын зураг төсөвт хийсэн 2021.05.29-ны

503/2021 дугаар магадлалын дүгнэлтийг норм ба дүрэм, стандартын дагуу боловсруулсан эсэхийг хянаж мэргэжлийн экспертүүд баталгаажуулсан байна.

А.3. Төсөл арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилтийг хангаагүй байна.

А.3.1. Шинээр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэн төлөвлөжээ.

Архангай аймагт 2021 онд шинээр хэрэгжүүлэхээр ТЕЗ нараас эрх шилжүүлсэн 16 ТАХ-нээс их засварын 12, тоног төхөөрөмжийн 3 арга хэмжээг орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэн төлөвлөсөн байна.

График 4.



Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөл /150 ор/-ийн ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөхдөө аймгийн ТЕЗ болон ТШЗ-нарын хүсэлт, суралцаж буй хүүхдийн тоонд үндэслэсэн нь оновчтой байна.

А.3.2. Шинээр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна.

Архангай аймагт 2021 онд шинээр хэрэгжүүлэхээр ТЕЗ нараас эрх шилжүүлсэн болон эрх шилжээгүй 30 ТАХ-г Сангийн Сайдын 2018 оны 295 дугаар тушаалын 3 ба 4-р хавсралтаар баталсан аргачлалын дагуу төсөвлөлтийн шаардлагыг хангуулж үнэлгээ өгсөн, эрэмбэлсэн байдал, нотлох баримтуудыг үнэлэхэд Төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээс энэ талаарх мэдээллийг харах боломжгүй бөгөөд , аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалтын хэлтэст баримт материал байхгүй байна. Харин аймгийн Засаг даргын 2020.04.30-ны өдрийн 02/554 тоот албан бичгээр 6 яаманд 35 ТАХ-г хэрэгжүүлэх саналыг хүргүүлснийг цахим системээс мэдээллийг бүрэн харах боломжгүй байна.

А.3.3. Нэг төсөл, арга хэмжээний санхүүжилтийг боломжит хугацаанд хэрэгжих байдлаар тооцож батлуулаагүй байна.

ТЕЗ нараас эрх шилжүүлсэн 2021 онд шинээр хэрэгжүүлэх 16 ТАХ-ний санхүүжилтийг оновчтой тооцож батлуулсан эсэхэд дүн шинжилгээ хийж үзэхэд 1 төсөл, арга хэмжээ буюу Өлзийт сумын Өөлд бээсийн хийдийн их засварын ажлын төсөвт өртгийг 2 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр тооцож санхүүжилтийг батлуулсан нь оновчгүй байна.

Хүснэгт 3. Санхүүжилтийг оновчгүй тооцож батлуулсан ТАХ-ний жагсаалт

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг (сая. төг)	Санхүүжилт батлагдсан	
			2021 онд олгох	2022 онд олгох

XIV.2.17	Соёлын өвийг сэргээн засварлах /Архангай, Өлзийт сум, Өөлд Бээсийн хийд/	150.0	100.0	50.0
Дүн		150.0	100.0	50.0

Нэг жилийн дотор хэрэгжиж дуусах боломжтой их засвар, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг ийнхүү 2 хувааж батлуулсан нь дараах эрсдлийг бий болгож байна. Үүнд:

1. Тухайн арга хэмжээний нэн шаардлагатай байгаа хэрэгцээ хангагдахгүй болж үр өгөөж хүртэх хугацаа хойшлох
2. Их завсарын чанарт сөргөөр нөлөөлөх
3. Материалын үнэ нэмэгдснээр батлагдсан төсвөөс хэтрэх шалтгаанаар дутуу орхигдох, үр ашиггүй нэмэлт зардал гарч төсвийг хохироож болзошгүй байна.


Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тухайн орон нутагт зайлшгүй шаардлагатай, төлөвлөсөн хугацаанд үр ашгийг нь хүртэх, засварын ажлын санхүүжилтийг он дамжуулан хэрэгжихээр хуваарилалгүйгээр батлуулж байх шаардлагатай байна.

А.3.4. Жагсаалтанд батлагдсан төсөл арга хэмжээ бүр нь хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл арга хэмжээ байна.

Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан эсэхийг шалгахад ТЕЗ-аас эрх шилжүүлсэн жагсаалтанд тусгагдсан 39 ТАХ нь бүгд Төсвийн тухай хуулийн 4.1.24¹-д заасан тодорхойлолттой нийцсэн хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл арга хэмжээ байна.

График 5.

ТЕЗ-аас хөрөнгө оруулалтын төрлөөр ангилж харуулбал: /Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан ангилалаар/



¹ “Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг”

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР
ХЭРЭГЖСЭН ТАХ-НИЙ 23.2 ХУВИЙГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.**

Б.1. Нийт төсөл, арга хэмжээний 93.7 нь худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичигт тавигдсан шаардлагыг хангасан.

Б.1.1. ТАХ-ний 93.7 хувийг тайланд онд хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.

УТХО-аар 2021 онд шинээр хэрэгжүүлэх 16 төсөл арга хэмжээг МУЗГ-ын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны 15 дугаар тогтоол, БШУС-ын 2021 оны А/13, А/60, Соёлын Сайдын 2021 оны 1а/246, ЭМС-ын 2021 оны А/521 дугаар тушаалуудаар тус тус эрх шилжүүлэн тендер, худалдан авалтыг орон нутагт зохион байгуулахаар төлөвлөсөн байна. ТЭЗ нар 2021 оны 1, 2-р улиралд 15 ТАХ-ний эрх шилжүүлэх шийдвэр гаргасан нь тендер шалгаруулах боломжит хугацаанд эрх шилжүүлсэн гэж үзэхээр байна. Харин 2021 оны 3-р улиралд ЭМЯ-наас Эрдэнэбулган сумын Хоршоололын Эрүүл мэндийн төвийн их засварын ажлын эрхийг шилжүүлсэн нь тухайн төсөл, арга хэмжээ тайлант онд хэрэгжих боломжгүй болж он дамжихад хүргэсэн байна.

Б.1.2. Нэг ТАХ-ний эрхийг оройтож шилжүүлсэнтэй холбоотойгоор худалдан авах ажиллагаа төлөвлөгдсөн хугацаанд зохион байгуулагдаагүй байна.

Тайлант онд шинээр хэрэгжих 16 ТАХ-ний Үнэлгээний хороог төлөвлөснөөс 9-180 хоногийн дараа байгуулах шийдвэр гаргасан нь Төсвийн ерөнхийлөн захирагчдаас орон нутагт төсөл, арга хэмжээний эрхийг төлөвлөсөн хугацаанаас оройтож шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үүний улмаас 1 ТАХ-ний худалдан авах ажиллагааг 2021 оны 3 дугаар улиралд зохион байгуулсан ч гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, ажил эхлүүлэх хугацаа 7-180 хоногоор хойшилж он дамжсан байна. Үлдэх 15 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2021 оны эхний хагас жилд багтаан хэрэгжих боломжийг хангах хугацаанд зохион байгуулсан байна.

Б.1.3. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан байна

ТАХ-ний тендерийн баримт бичгийг Сангийн Сайдын 2012 оны 81 дүгээр тушаалаар баталсан жишиг баримт бичгийн дагуу боловсруулж, үнэлгээний хорооны анхны хуралдаанаар хэлэлцэн, урилга нийтэлсэн өдөр батлуулсан байна.

Эрх шилжүүлсэн бүх тендерийн урилгыг www.tender.gov.mn цахим сайт болон өдөр тутмын Монголын үнэн зэрэг сонинд нийтлүүлж ил тод мэдээлсэн ба Сангийн Сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3 дугаар зүйлийн хүрээнд 100 хувь цахимаар зохион байгуулжээ.

Б.1.4. Нийт төсөл, арга хэмжээний 93.7 нь худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичигт тавигдсан шаардлагыг хангасан байна.

Тайлант жилд шинээр хэрэгжүүлсэн 16 ТАХ-ний сонгон шалгаруулалтын материалыг шалгахад худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичигт тавигдсан шаардлагын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Харин Батцэнгэл сумын “Авга дугана” Соёлын өвийг сэргээн засварлах ажлын худалдан авах ажиллагааг 2 удаа зохион байгуулсан ч шаардлага хангасан тендер ирүүлээгүйд захиалагч байгууллагаас түүх, соёлын барилга байгууламжийн сэргээн засварлалт, угсралт, өргөтгөл, шинэчлэлийн тусгай зөвшөөрөлтэй “Хот мандал Эм Жи Эл” ХХК-тай хэлэлцээ хийж, шууд гэрээ байгуулжээ.

Хэлэлцээ хийхдээ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.2-т заасны дагуу тухайн ажлыг гүйцэтгэх инженер, техникийн ажилтан, техникийн тодорхойлолт, бусад нөхцөл, шаардлагыг хангасан эсэх баримт материалыг гүйцэтгэгч байгууллагаас гаргуулаагүй, хянаж баталгаажуулалгүйгээр гэрээ байгуулсан байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг зөрчсөн тул хөрөнгө оруулалтын арга хэмжээнд хэлэлцээ хийж шууд гэрээ байгуулахдаа хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн ОНӨГ-т хүргүүлээ.

Б.1.5. Худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж хугацаанд нь тайлагнажээ.

Архангай аймгийн ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны 2021 оны тайланг ОНӨГ-ын 2021.12.23-ны өдрийн №640 тоот албан бичгээр Сангийн яамны хууль эрхзүйн газарт хүргүүлсэн нь Сангийн Сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.1.5 дахь заалтын дагуу заасан хугацаанд хүргүүлсэн байна. 2022 оны 04 дүгээр сарын 27-ны байдлаар Сангийн яамнаас 2021 оны аймгийн ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хийсэн үнэлгээ гараагүй байна.

Аймгийн ОНӨГ-ын сүүлийн 5 жилийн ХАА-ны журмын сонголтыг харьцуулсан графикаар харуулбал:




График 6.

Архангай аймгийн ОНӨГ нь 2021 онд улс, орон нутгийн төсвийн болон байгууллагын захиалгаар нийт 79 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнээс 16 нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжүүлсэн ба 13 арга хэмжээг харьцуулалтын, 3 арга хэмжээг нээлттэй

аргаар зохион байгуулахаар төлөвлөж хэрэгжүүлсэн байна. /Дэлгэрэнгүй Хавсралт №2/

Сүүлийн жилүүдэд нээлттэй тендер шалгаруулалт 2019, 2020 онд өмнөх онуудаас өсч 63 хувь хүрч байгаа нь ТЕЗ нараас эрх шилжүүлсэн ТАХ-ний төсвийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Б.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулаагүй байна.

Б.2.1. 2021 онд ашиглалтанд оруулах нийт ТАХ-ний 32.2 хувь нь гэрээний хугацаанд хэрэгжээгүй он дамжсан байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид 2020-2021 онд эрх шилжүүлсэн 39 ТАХ-нээс 3 нь санхүүжилт олгогдоогүйгээс хэрэгжээгүй, 5 нь он дамжин хэрэгжих буюу гэрээний хугацаа дуусах болоогүй байна. Үлдэгдэл 31 нь 2021 онд хэрэгжихээс 21 нь бүрэн хэрэгжиж, 10 нь гэрээний хугацаанд хэрэгжээгүй он дамжсан байна.

Хүснэгт 4: Гэрээний үүргээ хугацаанд нь хэрэгжүүлээгүй гүйцэтгэгчийн талаарх мэдээлэл

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Багцын нэр	Гүйцэтгэгч	Гэрээний үнэ /сая.төг/	Гэрээний эцсийн хугацаа
1	V.1.2.4	Засаг даргын Тамгын газрын их засвар /Архангай, Ихтамир сум/		"Энх төгс тэмүүлэл" ХХК	296.0	2021.11.15
2	XIII.1.3.18	Боловсролын чанарыг сайжруулах төсөл хөтөлбөр /Архангай/	Багц 2 Чадварлаг багш ТАХ-ний хүрээнд боловсролын салбарт тоног төхөөрөмж нийлүүлэх	Саммит компьютер технологи ХХК	224.6	2021.07.23
3		Архангай аймгийн Эрдэнэбулган, Цэнхэр, Төвшрүүлэх сумдын сургуулиудад компьютер, техник хэрэгсэл нийлүүлэх	Багц 1 Компьютер техник хэрэгсэл /Эрдэнэбулган, Цэнхэр, Төвшрүүлэх/	АЙ ТИ ЗОН ХХК	232.1	2021.11.15
4	XIII.1.1.41	Сургуулийн барилга, 320 суудал /Архангай, Хайрхан сум/		Эртний цамхаг ХХК	2,851.50	8/31/2021
5	XIII.1.1.82	Сургуулийн барилгын өргөтгөл /Архангай, Өлзийт сум/		Ди Ти иэм строй ХХК	790.1	6/1/2021
6	XIII.1.1.83	Сургуулийн барилгын өргөтгөл /Архангай, Хашаат сум/		Тамирын цахиур ХХК	923.0	2021.08.01
7	XIII.1.1.191	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 50 ор /Архангай, Тариат сум/		Хорго групп ХХК	482.00	2021.12.15
8	XIV.1.14	Соёлын төвийн барилга /Архангай, Булган сум/		Газрын гагнаас ХХК	1,112.9	8/30/2021
9	XIV.1.15	Соёлын төвийн барилга /Архангай, Жаргалант сум/		Газрын гагнаас ХХК	1,081.7	2021.12.25
10	XIV.1.16	Соёлын төвийн барилга /Архангай, Чулуут сум/		Эсгэл ХХК	1,102.0	8/25/2021

График 7.



2021 онд ашиглалтанд хүлээлгэн өгвөл зохих ТАХ-нээс 67.8% хугацаандаа хэрэгжсэн бол 32.2% буюу 10 ТАХ гүйцэтгэгчээс шалтгаалан он дамжин хэрэгжиж байна.

Аудитаар дараах 7-н ТАХ-ний гүйцэтгэгч нар гэрээт ажлыг дутуу болон чанаргүй гүйцэтгэсэн нь шалгалтын явцад илэрлээ. /Гүйцэтгэл дутуу ТАХ-г зургаар баталгаажуулсан байдлыг хавсралт 6-аас дэлгэрэнгүй үзнэ үү/ Үүнд:

- Цагаан сүмбэр ХХК нь “Хангай сумын соёлын төв, спорт заалны их засвар”-ын ажилд модон шал 30 хувь шинэчлэх ажлыг дутуу хийсэн ба зарим өрөөний разетик ажилладаггүй, спорт зааланд шинээр 8 гэрэл тавьснаас 5 нь шатсан, гэрэлтүүлэг муу, модон шал 2 хэсэг газарт цөмөрсөн зэрэг чанаргүй гүйцэтгэсэн байна.
- Газрын гагнаас ХХК-ний гүйцэтгэсэн “Өндөр-Улаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 50 ортой барилгын их засвар”-ын ажилд зураг төсвийн дагуу гүйцэтгэх бүх өрөөний хаалгыг 2 давхарлаж будаагүй, зарим хэсэг нь будаагүй, ариун цэврийн өрөөний гэрэлтүүлгийг таазанд суурилуулаагүй сул орхисон мөн барилга ашиглалтанд оруулах үед улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, анги бүлгийн болон нягтлангийн өрөөний паркетан шал овойж, хөдөлгөөн орж эвдрэл гэмтэл үүссэн байна.
- Тамир таун ХХК-ний гүйцэтгэсэн “Өндөр-Улаан сумын Хануй багийн сургуулийн барилгын өргөтгөл”-ийн ажил ашиглалтын явцад коридорт болон хичээлийн танхимуудад пракетан шал хөөж овойсон, шал хөдөлгөөнтэй, цонхны шил цуурсан, цэвэр бохир усны ажлыг бүрэн гүйцэтгээгүй байна.
- Өлзийт сумын цэцэрлэгийн барилгын дээврийн засварыг 39.7 сая төгрөгөөр гүйцэтгэхээр Оюутбилгүүн ХХК аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан байна. Их засварын ажлыг ашиглалтанд хүлээлгэн өгсөн бөгөөд ажлын гүйцэтгэлийг шалгахад зураг төсвийн дагуу хийгдэхээр тусгасан таазыг хусаж, замаск татах, эмульс хийх ажлууд хийгдээгүй байна.
- “Эвт уул” ХХК-ний гүйцэтгэсэн “Эрдэнэмандал сумын Хануйн гол дээр 90.9 у/м бетон гүүр” баригдсан ба ашиглагч байгууллагаас гүүрэнд гэрэлтүүлэг нэмэх, чиглүүлэгчийг байршуулах ажил хийгдээгүй байна.
- Бурхант хясаат ХХК, Эвт уул ХХК-ний гүйцэтгэсэн “Эрдэнэмандал сумын төвийн шинэчлэл”-ийн ажлыг 2020.06.16-2021.11.15-ны хооронд гүйцэтгэн улсын комисст 2021.11.30-нд хүлээлгэн өгсөн ба улсын комиссоос өгсөн 9 заалт бүхий дутуу ажлуудыг гүйцэтгээгүй байна.

- Ар дэн ХХК-ний гүйцэтгэсэн “Цэцэрлэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 50 ортой өргөтгөлийн барилга”-ын ажилд гадна тохижилтийн ажил хийгдээгүй, дотор талд 1 ба 2 дугаар давхрын хананд цууралт үүссэн, шавар нь хөндийрсөн, ховхрох эрсдэл үүссэн, цонхны шил хагарч цуурсан, цахилгааны шитний кабель утасны бүрээс хайлсан байна. Мөн ашиглагч байгууллагаас 1-р давхар халаалтын шугам задарсан, цонхноос дулаан алдалт ихтэй, аваарын 2 хаалгаар дулаан алддаг, цас, шороо орж ирдэг цахилгааны самбарын хүчин чадал муу байгаа нь үйл ажиллагаа хэвийн явуулахад хүндрэл учруулдаг гэсэн гомдлыг гаргасан.

Мөн аймгийн ТЕЗ-д эрх шилжээгүй 2020-2021 онд хэрэгжихээр батлагдсан 22 ТАХ-нээс 3 нь огт хэрэгжээгүй байна. Үлдэх 19-н барилга байгууламж, гүүрийн ажлууд тус бүрт бодит байдлыг газар дээр нь очиж хяналтын хуудас хөтөлж фото зургаар баримтжуулсан. Төсөл, арга хэмжээ тус бүрээр хөтөлсөн маягтыг УАГ-т хүргүүлсэн.

Иймд барилга байгууламжийн ажлыг шалгах явцад гарсан зөрчлийг барагдуулж, эвдрэл гэмтлийг засварлуулах, дутуу ажлыг гүйцэтгүүлэх арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүллээ.

Б.2.2. Нийт ТАХ-ний 7.4 хувьд захиалагчийн тавих хяналтыг үр дүнгүй хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ТЕЗ-д эрх шилжүүлсэн 2020-2021 онд хэрэгжих нийт 39 ТАХ-нээс тоног төхөөрөмж нийлүүлэх 4, барилга байгууламж, их засварын 35 ажил байгаа бөгөөд 3 нь огт хэрэгжээгүй он дамжсан байна. Үлдэх 32 барилга байгууламж их засварын ажлуудаас 5 нь дараа онд шилжин хэрэгжих буюу гэрээний хугацаа дуусах болоогүй байна. Үлдэгдэл 27 нь барилга байгууламж, их засварын ажлууд дуусах гэрээтэйгээс 19 нь бүрэн хэрэгжсэн, 8 нь гэрээний хугацаанд гүйцэтгээгүй он дамжсан байна.

Гэрээний хугацаанд гүйцэтгээгүй он дамжсан 8 ТАХ-нд явцын хяналт тавьж ажилласан эсэхийг газар дээр нь очиж тулган шалгахад захиалагч, зохиогчийн зүгээс үе шатны ажлыг тухай бүр хянаж илэрсэн зөрчил, өгсөн зөвлөмжийн талаар талбайн журналд тэмдэглэн, ил ба далд ажлын гүйцэтгэлийг актаар баталгаажуулан, захиалагчийн явцын дүгнэлтийг гаргаж ажилласан хэдий ч Тариат сумын 50 ортой Хүүхдийн цэцэрлэгийн барилга, Хайрхан сумын 320 хүүхдийн барилгын өргөтгөлийн ажлуудад бодит гүйцэтгэлээс зөрүүтэйгээр тооцсон санхүүжилтийн гүйцэтгэлийг баталгаажуулж санхүүжилт олгосон нь захиалагч байгууллагын явцын хяналт үр дүнгүй хэрэгжсэн гэж үзэхэд хүргэж байна.

Б.2.3. Хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмж хууль эрхзүйн баримт бичигт заасны дагуу хэрэглэгчдэд хүрсэн ч зарим тоног төхөөрөмж ашиглалтын явцад эвдэрсэн байна.

ТЕЗ нараас 2021 онд 935.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 821.0 сая төгрөгөөр санхүүжих дүнтэй машин, тоног төхөөрөмж худалдан авах 4 ТАХ-ний эрхийг шилжүүлсэн байна. Үүнээс 1 нь бүрэн хэрэгжиж тоног төхөөрөмжийг хүлээн авсан



бөгөөд Эрдэнэбулган, Цэнхэр, Төвшрүүлэх сумдын сургуулиудад компьютер, техник хэрэгсэл нийлүүлэх, Сум, багийн хөгжлийг дэмжих төсөл, Боловсролын чанарыг сайжруулах төслийн 2021 онд батлагдсан төсвийн хэмжээнд хэрэгжиж үлдэх тоног төхөөрөмжийг 2022 онд хэрэгжүүлэхээр он дамжсан байна. Сумдад ажилласан баг сургууль, цэцэрлэг, эмнэлэг, сумын ЗДТГ-т хуваарилсан машин, тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал, санхүү бүртгэлд тусгасан эсэхийг тулгаж баталгаажуулсан.

Боловсролын чанарыг сайжруулах төслийн хүрээнд бэлтгэн нийлүүлсэн машин, тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлсэн ч ашиглалтын явцад Чулуут сумын ЕБС-ийн нэг зөөврийн компьютерийн гар ажиллахгүй байгаа, Жаргалант сумын хүүхдийн цэцэрлэгт олгосон өнгөт принтер хүлээн авснаас хойш ажиллаагүй байна.

Б.2.4. Өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон 5 барилга, байгууламж байна.

Аймгийн ТЕЗ-д 2020-2021 онд эрх шилжсэн 39 ТАХ-нээс шинээр хэрэгжих 1 ТАХ нь Эрүүл мэндийн яамнаас 2021 оны 3 дугаар улиралд эрх шилжүүлсэнтэй холбоотойгоор он дамжсан, өмнөх оноос шилжсэн 2 ТАХ нь 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад санхүүжих эх үүсвэрийг тусгаж батлаагүй тул хэрэгжээгүй байна.

Мөн өмнөх оноос дамжсан эрх шилжээгүй 3 ТАХ нь 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын дүнд санхүүжилт нь батлагдаагүй тул хэрэгжээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаад дуусаагүй, орхигдсон барилга байгууламжийн судалгаа

Хүснэгт 5

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Гүйцэтгэгч	Гэрээний		Гүйцэтгэж дуусах хугацаа
			Эхлэх	Дуусах		Байгуулсан	Гэрээний үнэ	
1	XIII.1.1.48	Солийн Данзангийн нэрэмжит музей, цэцэрлэгт хүрээлэн /Архангай, Хотонт сум/	2019	2021	Жоншт ХХК	7/19/2019	1,000.0	8/30/2020
2	V.1.4	Өгийнуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах /Архангай/	2019	2021	Эвт Уул ХХК	8/5/2019	3,991.7	11/30/2020
3	XIV.1.4	Аймгийн хөгжимт драмын театрын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/	2012	2021	"Акми Холдинг" ХХК	2012	6,707.3	07/01/2021
4		120 хүүхдийн дотуур байр /Архангай, Өгийнуур сум/	2019	2021	"Хатант констракшн" ХХК	2019.12.13	1,449.3	12/31/2020



5		Хүүхэд залуучуудын соёл үйлчилгээний цогцолбор, усан бассейн	2013	2021	"Эбо Сервис" ХХК	2013.06.25	2,416.0	12/31/2020
		Нийт дүн			-		15,564.3	

1. Хотонт сумын Солийн Данзангийн нэрэмжит музей, цэцэрлэгт хүрээлэн /XIII.1.1.48/

Уг барилга нь 2019 оноос хэрэгжиж эхэлсэн ба 2019 онд 600.0 сая төгрөгийн, 2020 онд 71.1 сая төгрөгийн нийт 671.1 сая төгрөгийн санхүүжилт олгогдож ажлын гүйцэтгэл 67%-тай байна. 2021 оны улсын төсөвт санхүүжилт батлагдаагүй тул хэрэгжээгүй, барилгын урд талын болон баруун хойд талын хэсэгт дүүргэлтийн хана хазайж, нурсан байдалтай байлаа. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагаас тус барилгын үлдэгдэл санхүүжилт 2022 оны улсын төсөвт батлагдсан тул гүйцэтгэгчийн гэрээг сунгаж барилгын ажлыг гүйцэтгүүлнэ гэсэн тайлбарын ирүүлсэн.

Аудитын дүгнэлт: Тус барилгын хийц, зураг төсөвт өөрчлөлт ороогүй харин санхүүжилтээс шалтгаалан хэрэгжээгүй орхигдсон байх тул гүйцэтгэгчээр дутуу ажлыг гэрээний хугацаанд чанартай гүйцэтгүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

2. Өгийнуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах / V.1.4/

Уг төсөл арга хэмжээ нь 2019 оноос хэрэгжиж эхэлсэн ба 2020 онд 1,737.2 сая төгрөгийн санхүүжилт олгогдож ажлын гүйцэтгэл 85%-тай хийгдсэн байна. 2021 оны улсын төсөвт санхүүжилт батлагдаагүйгээс хэрэгжээгүй байна. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагаас барилгын үлдэгдэл санхүүжилт 2022 оны улсын төсөвт батлагдсан тул гүйцэтгэгчийн гэрээг сунгаж барилгын ажлын ажлыг гүйцэтгүүлнэ гэсэн тайлбарын ирүүлсэн.

Аудитын дүгнэлт: Тус ажлын хийц, зураг төсөвт өөрчлөлт ороогүй харин санхүүжилтээс шалтгаалан хэрэгжээгүй орхигдсон тул гүйцэтгэгчээр дутуу ажлыг гэрээний хугацаанд чанартай гүйцэтгүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

3. Аймгийн хөгжимт драмын театрын барилга /XIV.1.4/

Аймгийн ТЕЗ-д эрх шилжээгүй БШУЯ-наас хэрэгжүүлсэн Хөгжимт драмын театрын барилга угсралтын ажилд анх 2013.06.28 гэрээ хийгдсэн, 2015.07.31, 2016.11.09, 2017.10.20, 2019.03.25, 2019.12.20, 2020.04.27, 2020.10.05 гэсэн хугацаанд 7 удаагийн гэрээний сунгалт болон нэмэлт гэрээ хийгдсэн байна. Тайлант онд 2021 оны 7 дугаар сарын 01-ны өдөр хүртэл гүйцэтгэж ашиглалтанд хүлээлгэн өгөхөөр сунгалтын гэрээ хийгдсэн ч он дамжсан байна.

Тус барилгын ажил нь 2013 онд эхэлсэн ба барилгын газар шорооны ажил, суурийн бэлтгэл бетоны ажил хийгдэж зогссон. 2014 онд улсын төсөвт хөрөнгө тусгагдаагүй царцаагдаж 2015, 2016 онд барилгын зоорийн давхарын каркас цутгалтын ажил, 2017 онд 1-р давхарын үндсэн хийц угсралтын ажил, 2018, 2019 онуудад 2-р давхарын болон галирейн хэсгийн үндсэн хийц угсралт, гадна өрлөгийн дүүргэлтийн

ажил, цонх суулгах ажил, гадна дулаан, гадна цэвэр бохир усны шугамын ажил, 2020-2021 онуудад гадна засал, дээвэр, дотор цахилгааны монтаж, дотор хамар ханын шавар, 2, 3-р давхарын цагаан замаскны ажил, гадна авто зам, зогсоол, явган зам, шилэн фасадны ажлууд хийж гүйцэтгэсэн. Нийт ажлын 68.4%-ийн хэрэгжилттэй бөгөөд барилга угсралтын ажил удаашралтай хэрэгжиж байна. 2022 оны 04-р сарын 13-ны өдрийн байдлаар гадна метал рамтай шилэн хаалга, метал фасад, салхивчны ажлууд хийгдэж байна. 2022 онд улсын төсөвт үлдэгдэл санхүүжилт батлагдсан тул гүйцэтгэгч компаниар үргэлжлүүлэн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгүүлэх боломжтой гэсэн тайлбарыг аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн.

Аудитын дүгнэлт: Тус хөрөнгө оруулалтын ажил нь удааширсанаас шалтгаалан 2013 оноос одоог хүртэл хийгдэж байгаа ба захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагаас 2022 онд бүрэн хэрэгжүүлж дуусгах боломжтой тайлбарыг ирүүлсэн тул уг ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх саналтай байна.

4. Өгийнуур сумын 120 хүүхдийн дотуур байрны барилга

БШУЯ-аас эрх шилжээгүй 2019 оноос хэрэгжсэн Өгийнуур сумын 120 хүүхдийн дотуур байрны барилгын ажлын гүйцэтгэгч "Хатант Констракшн" ХХК-д 2020 онд 800.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон, 2021 онд санхүүжилт хуваарилаагүй тул ажил хийгдээгүй байна. Ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь очиж шалгахад барилгын 1, 2 давхарын карказ, багана цутгасан боловч зарим багана, ирмэгүүдийн бетон үүрч бутарч унасан байна. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагаас ШУТИС-ийн барилга архитектурын сургуулийн оношлогоо, зураг төсөл, судалгааны "Ре констракшн төв"-тэй гэрээ байгуулан суурь, карказад дүгнэлт гаргуулж зохиогч байгууллагаар хүчитгэлийн зураг гаргуулан, магадлалаар хянагдаж байгаа ба тус барилгын үлдэгдэл санхүүжилт 2022 оны улсын төсөвт батлагдсан тул гүйцэтгэгчийн гэрээг сунгаж барилгын ажлыг гүйцэтгүүлнэ гэсэн тайлбарыг ирүүлсэн.

Аудитын дүгнэлт: Тус барилгын төсөв санхүүжилт 2022 батлагдсан хэдий ч зураг төсөв, төсөвт өртөгийн хэмжээнд өөрчлөлт орохоор магадлалын ажил хийгдэж байгаа тул аудитаас өөрчлөгдсөн зураг төсөвт хийсэн магадлалын дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.

5. Хүүхэд залуучуудын соёл үйлчилгээний цогцолбор, усан бассейн

Аймгийн ТЕЗ-д эрх шилжээгүй БШУЯ-наас хэрэгжиж буй Хүүхэд залуучуудын чийрэгжүүлэлтийн төв "Усан бассейн"-ы барилга угсралтын ажил **анх** 2013.06.25 онд гэрээ хийгдэж 2015.04.16, 2015.12.15, 2017.09.05, 2018.10.22, 2020.05.01, 2020.11.27 гэсэн хугацаанд нийт 6 удаагийн гэрээний сунгалт болон нэмэлт гэрээ хийгдсэн.

Сүүлийн сунгалтын гэрээгээр 2020 оны 12-р сарын 31-ны өдөр ашиглалтанд хүлээлгэн өгөхөөр хийгдсэн бөгөөд КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж 2021 оны улсын төсөвт санхүүжилт батлагдаагүй тул он дамжсан байна.

Барилгын ажил нь 2013 онд эхэлсэн ба барилга угсралтын ажил 95%-тай 2022 оны 04-р сарын 13-ны өдрийн байдлаар 72 м2 уян тааз угсрах, дотор вакум хананы шилэлгээ хийх, 2-р давхарын өрөөний шалны хөвөө хадах, гадна фасад хууларч өнгөө алдсан тул дахин сэргээн будах, тоног төхөөрөмжийн туршилт тохируулга хийх ажлууд дутуу байна. 2022 онд үлдэгдэл санхүүжилт батлагдсан тул гүйцэтгэгч компаниар үргэлжлүүлэн барилга угсралтын ажлийг хийж дуусгах боломжтой гэсэн тайлбарыг ирүүлсэн.

Аудитын дүгнэлт: Барилгын ажлын хийц, зураг төсөвт өөрчлөлт ороогүй санхүүжилт батлагдсан тул гүйцэтгэгчээр дутуу ажлыг гэрээний хугацаанд чанартай гүйцэтгүүлэх нь зүйтэй гэж үнэлэлээ.

Б.2.5. Аймгийн ТЕЗ-д эрх шилжин хэрэгжсэн ТАХ-нд ТЭЗҮ боловсруулах ажил хийгдээгүй байна.

Тайлант онд эрх шилжин хэрэгжсэн 39 ТАХ-нээс барилга байгууламжийн 18, их засварын 16, тоног төхөөрөмжийн 4, гүүрийн 1 ажил хийгдсэн байна. Харин улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ТЭЗҮ боловсруулах ажил хийгдээгүй байна.

Б.3. Нийт ТАХ-ний 7.4 хувьд гэрээний хэрэгжилтэнд захиалагчийн тавих хяналт үр дүнгүй, аймгийн Засаг даргаас хөрөнгө оруулалтын үйл явц, хэрэгжилт, үр дүнд дотоод хяналт шалгалтыг хийгээгүй байна.

Б.3.1. Төсөл арга хэмжээний хэрэгжилтэнд зохиогч болон захиалагчийн хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж, үе шатны хяналтыг хэрэгжүүлж, баталгаажуулж ажилласан байна.

Аймгийн ТЕЗ-д эрх шилжүүлсэн 2020-2021 онд хэрэгжихээр батлагдсан нийт 39 ТАХ-нээс тоног төхөөрөмж нийлүүлэх 4, барилга байгууламж, их засварын 35 ажил байна. Өөрөөр хэлбэл захиалагч, зохиогчийн хяналт хэрэгжүүлбэл зохих барилга байгууламж, их засварын 35 ажлаас 3 нь хэрэгжээгүй, 5 нь гэрээгээр он дамжсан, 27 ТАХ нь тайлант онд ашиглалтанд орох гэрээтэйгээс 19 нь хугацаандаа ашиглалтанд орсон, 8 нь гэрээний хугацаанд хэрэгжээгүй он дамжсан байна.

Ашиглалтанд орсон 19 нь барилга байгууламж, их засварын ажлуудад Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5.3, 48.5.4, 48.7.1 дэх заалтын хүрээнд захиалагчийн болон зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлтийг гаргаж, гэрээг дүгнэсэн байна.

Гэрээний хугацаанд хэрэгжээгүй он дамжсан 8- н төсөл арга хэмжээнд захиалагч, зохиогчийн хяналтыг тухай бүрт нь хийж талбайн журналд үүрэг даалгавар, зөвлөмжийг тэмдэглэж, биелэлтийг тооцсон ба барилга байгууламжийн ил, далд ажлыг актаар баталгаажуулан, захиалагчийн явцын дүгнэлтийг гаргаж ажилласан байна.

Б.3.2. Зарим ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.



Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 39 ТАХ-ний 2021 оны санхүүжилт 25 тэрбум 358.4 сая төгрөг хийгдэхээс аймгийн Төрийн сангийн дансаар 39 ТАХ-ний 20 тэрбум 350.3 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

Санхүүжилтийн гүйцэтгэлийг авч үзвэл:

1. БСШУСайдын багцаас 12 тэрбум 511.4 сая төгрөг
2. ЗГХЭГ-ын даргын багцаас 375.9 сая төгрөг
3. Соёлын Сайдын багцаас 3 тэрбум 149.3 сая төгрөг
4. БХБСайдын багцаас 4 тэрбум 79.6 сая төгрөг
5. ЭМСайдын багцаас 99.9 сая төгрөг
6. ЗТХЯамнаас техник хяналтын зардалд 134.2 сая төгрөг

нийт 20 тэрбум 350.3 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдснээс гүйцэтгэгч нарт 15 тэрбум 778.9 сая төгрөгийг олгосон байна.

Санхүүжилтийн зарцуулалтыг дэлгэрэнгүй байдлаар харуулбал:

Хүснэгт 6.

Нийт санхүүжилт	20350.3
Гүйцэтгэгчид олгосон	15778.9
Зураг төсвийн үнэ	112.4
Хяналтын зардалд	166
барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан	4158.7
Техник хяналтын зардлын дансанд	134.2

ТЕЗ нар ТАХ-ний тухайн жилд батлагдсан санхүүжилтийн 80.2 хувийг олгосон байна.

Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 39 ТАХ-ний 2021 онд санхүүжүүлэхээр батлагдсан төсөв 25 тэрбум 358.4 сая төгрөг бөгөөд аймгийн Төрийн сангийн хөрөнгө оруулалтын дансанд Сангийн яамнаас 2021 онд нийт 20 тэрбум 350.3 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. (ТАХ бүрээр санхүүжилтийн дэлгэрэнгүйг Хавсралт 3-аас үзнэ үү)

Хүснэгт 7. ТАХ-ний санхүүжилтийг ТЕЗ нараар ангилж хүснэгтээр харуулбал:

ТЕЗ	Эрх шилжүүлсэн		Санхүүжилт хийгдсэн		Зөрүү	
	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжилтийн дүн	ТАХ-ний тоо	Санхүүжилтийн дүн
СС	6	3250.0	6	3149.3	-	100.7
БШУС	24	12521.4	24	12511.4	-	10.04
ЗГХЭГ	3	400.0	3	375.9	-	24.08
БХБС	2	4082.5	2	4079.6	-	2.9
БОАЖС	1	2000.0	-	0.0	1	2000
ЭМС	2	104.5	2	99.9	-	4.6
ЗТХС	1	3000.0	1	134.2	-	2865.8
	39	25358.4	38	20350.3	1	5,008.1

Барилга байгууламжийн бодит гүйцэтгэлийн байдлыг газар дээр нь тулган шалгахад дараах 2 ТАХ-нд илүү санхүүжилт олгосон байна. Үүнд:

- Тариат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 50 ортой өргөтгөлийн барилгын ажлыг 482.0 сая төгрөгөөр 2019.08.12-2019.10.22-ны хооронд гүйцэтгэхээр Хорго групп ХХК нь аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан. Гүйцэтгэлээр 2019 онд 144.6 сая төгрөгийн санхүүжилт авсан ба үлдэх 337.4 сая төгрөгийн санхүүжилт нь 2020 оны улсын төсөвт суугдаагүй байна. 2021 онд батлагдсан бөгөөд хана хамар, хучилтын ажил хийсэн гэж 187.5 сая төгрөгийн санхүүжилт авсан нь бодит гүйцэтгэлтэй тохирохгүй байна. Бодит гүйцэтгэлийг ажлын хэсэг үзэж танилцахад зөвхөн 1-р давхарын карказ, шат цутгасан байв.
- Хайрхан сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын өргөтгөлийг 2,851.5 сая төгрөгөөр 2020.05.22-2021.08.31-ны хооронд гүйцэтгэхээр "Эртний цамхаг Констракшн" ХХК нь аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан байна. Гүйцэтгэлээр 2020 онд 400.0 сая төгрөгийн санхүүжилт авсан ба үлдэх 2,451.5 сая төгрөгийн санхүүжилт нь 2021 онд батлагдсан бөгөөд 1, 2 давхарын хана, хамар ханын ажил, дээврийн ажил, хаалга, цонхны ажил, дотор гэрэлтүүлэг, холбоо дохиололын ажлыг зураг төсвийн дагуу хийсэн гэж 481.7 сая төгрөгийн санхүүжилт авсан нь бодит гүйцэтгэлтэй тохирохгүй байна. Бодит гүйцэтгэлийг ажлын хэсэг үзэж танилцахад зөвхөн 1, 2 давхарын карказ, шал, шат цутгасан бөгөөд ажлыг зураг төсвийн дагуу чанартай хийж байгаа байдал ажиглагдлаа. */Гүйцэтгэгчийн ирүүлсэн тайлбараас үзэхэд ковидын нөхцөл байдал, сум орон нутгийн удирдлагын зүгээс болон материалын үнийн өсөлт зэргээс үүдэн ажлыг бүрэн хийж гүйцэтгэх боломжгүй байсан хэдий ч 2022 ондоо бүрэн хэрэгжүүлж дуусгана гэсэн тайлбарыг ирүүлсэн /*

Бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгох, гүйцэтгэлийн баталгаагаар хийгдсэн гэх дутуу ажлуудыг гүйцэтгэгч байгууллагаар гэрээний хугацаанд, чанартай гүйцэтгүүлэх арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлж байна.

Б.3.3. Хөрөнгө оруулалтын үйл явц, хэрэгжилт, үр дүнд аймгийн Засаг даргаас дотоод хяналт шалгалт хийгээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс, СХАА-наас улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулаагүй нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан байна. */эх сурвалж: СХАА-ны 2022 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн 71 дугаар албан бичгийг үндэслэв/* Үүнээс үзэхэд хөрөнгө оруулалтын явцад тавих аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналт хангалтгүй байна.

Иймээс Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14 дүгээр зүйлийн 14.2.8, 14.2.9, 14.2.10 дахь заалтын хэрэгжилтийг хангуулах, аймгийн ЗДТГ-ын ХШҮДА хэлтэс, СХАА-наас УТХО-ын хэрэгжилтийн явцад дотоод хяналт шалгалт хийх, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүлээ.

Б.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 8-н ТАХ-ний 9470.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн 22 хувийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Б.4.1. Засгийн газрын тогтоолын дагуу 2020 онд 1,722.1 сая төгрөг, 2021 онд барьцаа хөрөнгийн дансанд 4,158.7 сая төгрөгийг шилжүүлэн авч ТАХ-ний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна.

Тухайн жилийн санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор МУЗГ-аас батлагдсан санхүүжилтийн олгоогүй үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлэн дараа онд бодит гүйцэтгэлээр санхүүжилтийг олгох бодлогыг баримталжээ.

МУЗГ-ын 2020 оны 253, 2021 оны 397 дүгээр тогтоолын дагуу аймгийн Засаг даргын барьцаа хөрөнгийн дансанд 1 тэрбум 722.1 сая төгрөгийг шилжүүлж, 44 ТАХ-ний гүйцэтгэлд үндэслэн 1 тэрбум 561.5 сая төгрөгийн, 2021 онд 4 тэрбум 158.7 сая төгрөгийг шилжүүлэн авч 9 ТАХ-ний гүйцэтгэлд үндэслэн 1 тэрбум 531.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. (ТАХ бүрээр санхүүжилтийн дэлгэрэнгүйг Хавсралт 4-өөс үзнэ үү)

Барьцаа хөрөнгийн дансны үлдэгдэл 2022.04.19-ны байдлаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 55 ТАХ-ний 3,854.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Архангай аймагт ТЕЗ нараас эрх шилжүүлсэн 39 ТАХ-нээс 2021 онд 31 нь байнгын ашиглалтанд орж төлөвлөсөн зорилт үр дүнг хангах ёстой. Гэтэл 2021 онд 21 нь ашиглалтанд орсон буюу төлөвлөгөөний хэрэгжилт 67.8 хувьтай байна.

Хүснэгт 8: Барьцаа хөрөнгийн дансны гүйлгээний нэгтгэл

Дансны нийт үлдэгдэл		Дансны үлдэгдлийг ангилбал,							
		Төсөл, арга хэмжээний барьцаа		Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт		ОНХС-ийн санхүүжилт		Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт	
Огноо	Мөнгөн дүн	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн
4/19/2022	3,854.11	55	3,854.11	37	2,904.03	14	718.63	4	231.45

Б.4.2. Өмнөх онуудад ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн данснаас гүйцэтгэлийн баталгаагаар олгосон төсөл, арга хэмжээний хэрэгжилт 72.7 хувьтай байна.

МУЗГ-ын 2020 оны 253 дугаар тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд 2020 онд 1 тэрбум 722.1 сая төгрөгийг шилжүүлэн авч 44 ТАХ-ний гүйцэтгэлд үндэслэн 1 тэрбум 561.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгож 72.7 хувь буюу 32 ТАХ ашиглалтанд орж 27.3 хувь буюу 12 ТАХ он дамжсан байна. Үлдэгдэл 160.5 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд үлдэгдэлсэн байна.



Б.4.3. 2021 онд ашиглалтанд орсон 8-н ТАХ-ний 9470.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байна.

УТХО-аар эрх шилжүүлсэн 15 тэрбум 65.8 сая төгрөгийн гэрээний үний дүн бүхий 21 ТАХ-г 2021 онд холбогдох комиссын актаар байнгын ашиглалтанд хүлээн авсан байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт №5-өөс үзнэ үү/

Хүснэгт 9: Ашиглалтанд хүлээн авсан ТАХ

Ашиглалтанд орсон		Үүнээс							
		Шинэ барилга байгууламж		Их засвар		Авто зам гүүр		Тоног төхөөрөмж	
Нийт ТАХ	Гэрээний үнийн дүн	ТАХ	Гэрээний дүн	ТАХ	Гэрээний дүн	ТАХ	Гэрээний дүн	ТАХ	Гэрээний дүн
21	15065.8	5	8730.9	13	2561.4	1	3498	2	265.4

Тайлант онд ашиглалтанд хүлээн авсан 5 барилга байгууламж, 13 их засвар, 1 гүүр, 2 тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагууд бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна. Байнгын ашиглалтанд хүлээн авсан 21 ТАХ-нээс их засварын 3 ТАХ-г ашиглагч байгууллага бүртгэл тайланд тусгаагүй, барилга байгууламжийн 5 ТАХ-г аймгийн ОНӨГ бүртгэлд тусгаагүй байна.

Хүснэгт 10: Бүртгэлд тусгаагүй хөрөнгийн жагсаалт.

ТАХ-ний нэр	Хуулийн код	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээний дүн	Улсын комиссын актын дугаар, Огноо		Тусгагдаагүй шалтгаан, тайлбар
6 дугаар цэцэрлэгийн их засвар /Архангай, Эрдэнэбулган сум/	XIII.3.1.2.15	Констант констракшн ХХК	188.0	ББАОКД-2021/62	2021.12.22	Бүртгэлд тусгаагүй
Сургуулийн барилгын их засвар /Архангай, Чулуут сум/	XIII.3.1.2.25	ИДУМ ХХК	93.9	ББАОК2021/22	2021.07.30	Бүртгэлд тусгаагүй
Сургуулийн барилгын их засвар /Архангай, Жаргалант сум/	XIII.3.1.2.26	Танацамхаг констракшн ХХК	95.2	ББАОК2021/01	2021.11.02	Бүртгэлд тусгаагүй
Хануйн голын төмөр бетон гүүр /Архангай, Эрдэнэмандал сум/	XV.2.1.7	Эвт-Уул ХХК	3,498.0	ЗТХЯ/12/2021	2021.11.25	Бүртгэлд тусгаагүй
Эрдэнэмандал сумын төвийн шинэчлэл	XI.1.100.3	Бурхант хясаат ХХК, Эвт уул ХХК	3,995.0	ББАОКД-2021/47	2021.11.30	Бүртгэлд тусгаагүй
Цэнхэрийн халуун рашаан орох сайжруулсан шороон зам /Архангай, Цэнхэр сум/	XV.1.1.66	эрх шилжээгүй	150.0	ашиглалтанд орсон		Бүртгэлд тусгаагүй
Шилэн кабельд холбох, 28 км	V.3.1.3	эрх шилжээгүй	250.0	ашиглалтанд орсон		Бүртгэлд тусгаагүй



/Архангай, Хашаат сум/						
Эрүүл мэндийн төвийн барилга 10 ортой /Архангай, Хайрхан сум/	ЭМЯ	эрх шилжээгүй	1200.0	ашиглалтанд орсон		Бүртгэлд тусгаагүй

Иймд улсын комиссын актаар хүлээн авсан боловч бүртгэл тайланд тусгаагүй их засварын 3 ТАХ-г ашиглагч байгууллагын бүртгэлд тусгуулах, 5-н барилга байгууламж, гүүрийн ажлуудыг бүртгэх талаар холбогдох ТЕЗ-д хандаж ТӨБЗГ-ын тогтоолыг гаргуулах арга хэмжээ авах зөвлөмжийг аймгийн ОНӨГ-т хүргүүлээ.

Б.4.4. Улсын төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй 2 ТАХ-ний магадлалын дүгнэлтээр 5.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг нэмэгдэхээр байна.

Аймгийн ТЕЗ-аас 2020-2021 онд эрх шилжин хэрэгжсэн 39 ТАХ-ний төсөвт өртөг үндэслэлгүйгээр нэмэгдсэн эсэхийг тулган шалгахад он дамжсан 2 ТАХ-ний төсөвт өртөг 5 тэрбум 178.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

- Цахир сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын ажлыг 2019 онд түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр “Лорд Скай” ХХК нь 3 тэрбум 150.0 сая төгрөгөөр 2019.10.04-2022.11.01-ны хооронд хийж гүйцэтгэхээр аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан байна. БХБЯ-ны Барилгын хөгжлийн төвөөс 2020.07.24-ны өдрийн Магадлалын нэгдсэн дүгнэлтээр барилгын ажлын төсвийг 3 тэрбум 953.8 сая төгрөгөөр буюу гэрээний үнийн дүнгээс 803.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж хянасан байна.
- Архангай аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилгын ажлыг 2020 онд түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр “Гурвантамир” ХХК нь 16 тэрбум 994.7 сая төгрөгөөр 2020.06.20-2021.12.01-ны хооронд хийж гүйцэтгэхээр ЭМЯ-тай гэрээ байгуулсан байна. БХБЯ-ны Барилгын хөгжлийн төвөөс 2020.12.15-ны өдрийн Магадлалын нэгдсэн дүгнэлтээр барилгын ажлын төсвийг 21 тэрбум 368.5 сая төгрөгөөр буюу гэрээний үнийн дүнгээс 4 тэрбум 374.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж хянасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад түлхүүр гардуулах нөхцлөөр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлийн явцад явцад магадлалын дүгнэлтээр төсөв нэмэгдсэн байна.

Б.4.5. Өмнөх аудитаар өгсөн 9 заалт бүхий зөвлөмжийн 22 хувийг хэрэгжүүлж ажиллаагүй, алдаа зөрчлийг давтан гаргасан байна

Өмнөх аудитаар Аймгийн Засаг дарга, ХОХБТХ, СТСХ, ОНӨГ-уудад нийт 9 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг албан бичгээр тооцож ирүүлсэнг тулган шалгахад аймгийн Засаг дарга 2 заалт бүхий зөвлөмжийг хэрэгжүүлээгүй алдаа зөрчлийг давтан гаргасан байна. Зөвлөмжийн биелэлт 77.8 хувьтай байна.

Хүснэгт 11.



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

Холбогдох албан тушаалтан	хүргүүлсэн зөвлөмжийн тоо	Хэрэгжээгүй	бүрэн хэрэгжүүлсэн
Аймгийн Засаг даргад	3	2	1
Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т	3	-	3
Аймгийн ЗДТГ-ын СТСХ-т	2	-	2
Аймгийн ОНӨГ-т	1	-	1
Дундаж хувь			77.8

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй давтан гаргасан аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүллээ.

-----oOo-----

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Эрх шилжүүлсэн нийт төсөл арга хэмжээний 87.5 хувь нь нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөгдсөн байна.
2. Барилга, байгууламжийн зураг, төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнтэй байна.
3. Төсөл арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилтийг хангаагүй байна.
4. Нийт төсөл, арга хэмжээний 93.7 нь худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичигт тавигдсан шаардлагыг хангасан.
5. Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулаагүй байна.
6. Нийт ТАХ-ний 7.4 хувьд гэрээний хэрэгжилтэнд захиалагчийн тавих хяналт үр дүнгүй, аймгийн Засаг даргаас хөрөнгө оруулалтын үйл явц, хэрэгжилт, үр дүнд дотоод хяналт шалгалтыг хийгээгүй байна.
7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 8-н ТАХ-ний 9470.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн 22 хувийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

УЛСЫН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨ БАГАТАЙ, ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН 67.8 ХУВИЙГ ХАНГАСАН БАЙНА.

Аудитын явцад нийт **10 тэрбум 239.3 сая төгрөгийн** зөрчил илэрсэнээс улсын комиссоос ашиглалтанд хүлээн авсан 9 тэрбум 470.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмжийг аймгийн ОНӨГ-т, бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон 669.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т, их засварын санхүүжилтийн төсвийг он дамжуулан хувааж баталсан 100.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, УТХО-ын төлөвлөлт, санхүүжилттэй холбоотой асуудлын талаарх асуудлыг ҮАГ-т уламжлан хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Мөн хөрөнгө оруулалтын ажлуудыг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй, ажлыг дутуу чанаргүй гүйцэтгэсэн зөрчлийг таслан зогсоох, гүйцэтгэгч байгууллагаар чанаргүй, дутуу гүйцэтгэсэн ажлыг бүрэн дуусгах арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан зөрчилд аймгийн Засаг даргад албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

-----oOo-----

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна .

Аймгийн Засаг дарга М.Батжаргалд

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй барилга байгууламжийн ажлын гүйцэтгэгчдэд тавих хяналтыг сайжруулах, гэрээний хугацаанд хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дуусаагүй, орхигдсон барилга байгууламжийг гэрээний хугацаанд чанартай гүйцэтгүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Амаржаргалд

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгох, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах

Аймгийн ОНӨГ-ын дарга Х.Ганхуягт

1. Улсын комиссын актаар ашиглалтанд хүлээн авсан их засварын 3 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгуулах, 5-н барилга байгууламж, гүүрийн ажлуудыг бүртгэх талаар холбогдох ТЕЗ-д хандаж ТӨБЗГ-аар шийдвэрлүүлж орон нутгийн өмчийн бүртгэлд тусгах арга хэмжээ авах
2. Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд хэлэлцээ хийж шууд гэрээ байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг мөрдөж ажиллах



Уламжлах санал:

Аудитын явцад ажиглагдсан зүйл, аудитын дүнд үндэслэн дараах асуудлыг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэхээр ҮАГ-т уламжилж байна.

Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтанд бодлогын баримт бичигт тусгагдаагүй ТАХ-ийг тусгахгүй байх
2. Нэг жилийн дотор хэрэгжих боломжтой төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 2 жил санхүүжүүлэхээр төлөвлөж батлуулахгүй байх арга хэмжээ авах
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санал хүсэлт болон хэрэгцээ шаардлагыг үндэслэн эрэмбэлж, төлөвлөж байх

Ингэснээр ТАХ-ний хэрэгжилт удаашрах, он дамжин хийгдэх, санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулах зэрэг эрсдлийг бууруулах боломжтой юм.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



МОНГОЛ УЛС
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

65139 Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 2 дугаар баг,

Утас/Факс: (976) 7033 3208,

И-мэйл: arkhangai.gov@gmail.com,

Вэбсайт: www.arkhangai.gov.mn


2022.04.29 № 01/757

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн аудитын тайлангийн төслүүдтэй танилцлаа.

Дээрх тайлангуудтай холбоотой ямар нэгэн санал байхгүй болно.



М.БАТЖАРГАЛ

65139-0220



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 11/08

Цэцэрлэг

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 9 дэх заалт, 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1, 2.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөөний дагуу "Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр ашиг, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангуудыг баталгаажуулсугай.

Хоёр. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

Гурав. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга М.Батжаргалд зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитын тайланг ҮАГ-ын Аудитын гуравдугаар газар, аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга болон шалгадагч байгууллагуудад хүргүүлж, аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аудитын хоёрдугаар нэгжийн ахлах аудитор /Х.Алтанчимэг/-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *T. Baygalmaa* Т.БАЙГАЛМАА



003013010



Архангай аймаг Төрийн Аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудиторын 2022 оны *10.10* тушаалын
Хавсралт №

“Архангай аймгийн авто замын сангийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн аудитаар илэрчсэн
алдаа зөрчлийн жагсаалт

№	Аудитын чиглэл/асуулт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (Мянган төгрөг)	Гаргасан шийдвэр
A	1	3	4	
1	Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх	Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөж батлахдаа Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2, 6.5.5 -д заасныг хэрэгжүүлээгүй, олон нийтэд нээлттэй мэдээлж оролцоог хангасан, эрэмбэ, дараалал тогтоох, шийдвэрлэх зэрэгт олон нийтийн саналыг харгалзан үзснийг нотлох баримтгүй байна.		Зөвлөмж өгөх
2	Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх	Өмнөх оноос шилжиж ирсэн 577.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 100.0 сая төгрөгөөр санхүүжих “Арслан цохио чиглэлийн чулуун хучилттай авто зам” нь 2022 онд үргэлжүүлэн хэрэгжүүлэхээр тооцож санхүүжилтийг хуваарилсан нь материалын зардал жил бүр нэмэгдэж байгаа өнөө үед батлагдсан төсөвт өртөгт багтаан хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэсэн байна. Үүний улмаас гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх гэрээг цуцлах хүсэлт гаргасныг хүлээн авч шийдвэрлэжээ. Мөн “Нэгдсэн эмнэлгийн авто зам, зогсоолын засвар”- ын ажил нь төсөвт өртөг хүрэлцэхгүй шалтгаанаар гүйцэтгэгч гэрээ байгуулахаас татгалзжээ. Үүнээс үзэхэд авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ач холбогдол эрэмбэ дарааллыг оновчтой тогтоогоогүй, төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй, санхүүжилтийг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож батлаагүй байна.		Зөвлөмж өгөх
3	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх	Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр Эрдэнэбулган сумын доторх авто зам, гуу жалганы эвдрэлийг жил бүр засварласан байна. Жил бүр үерийн улмаас эвдэрсэн гуу жалга, замыг засах биш дахин эвдрэл үүсэхгүйгээр байхаар үерээс хамгаалах далан, хоолой барих гэх мэт арга хэмжээг төлөвлөж зарцуулах нь зүйтэй байна.		Зөвлөмж өгөх
4	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх	Өмнөх аудитаас өгсөн Төсвийн тухай хуулийн 69.1 дэх заалтын хүрээнд авто замын сангийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, төсвийн зарцуулалтанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлээгүй байна.		Албан шаардлага 319/A0340210
	Нийт		-	

6	Улсын төсвийн оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу, г	2021 онд ашиглагдсан орсон 8-н ТАХ-ний 9470.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаггүй байна.	9,470.1	Зөвлөмж өгсөн
			10,139.3	-



Хавсралтууд: №1-4 Excel файлаар хийж хавсаргав.